



## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 19-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4 заалт, 47 дугаар зүйлийн 47.1 заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.6.12 дах заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 18-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашгаас 136,648,693.08 төгрөгөөс нэгж хувьцаанд 2.42 төгрөг буюу нийт 136,529,140 төгрөгийн ногдол ашгийг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Компанийн нийт гаргасан хувьцааны үндсэн 70% /39,491,900 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компаниас, олон нийтэд нээлттэй 30% /16,925,100 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд 2025 оны 04 сарын 30-ний өдрийн дотор олгохыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД